



МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/639

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын үйл ажиллагаанд, дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллага, төсөл хөтөлбөрийн удирдлагад үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Г.Саран), Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар (Т.Гантогтох)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Х.БОЛОРЧУЛУУН

1301010911

Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн Сайдын
2023 оны 12 дугаар сарын 01-ны
өдрийн 163 дугаар тушаалын
хавсралт

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,
САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ,
ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллага, төсөл хөтөлбөрийн ажлын үр дүнг дээшлүүлэх, төрийн үйлчилгээ үзүүлэхэд үүсэж буй эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааны зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, үр дүнг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” болон энэхүү журмыг удирдлага болгоно.

Хоёр. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааны зорилго

2.1 Дотоод хяналт шалгалтын зорилго нь яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын үйл ажиллагаа, иргэд, аж ахуйн нэгжид үзүүлж байгаа төрийн үйлчилгээг Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрт нийцүүлэн хүргэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, зөвлөмж өгөх, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Гурав. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааны зарчим, хамрах хүрээ

3.1 Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 2.1-д заасан хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчмыг баримталж ажиллана.

3.2 Батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллага, төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг энэхүү журмын хүрээнд гүйцэтгэнэ.

3.3 Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор салбарын улсын (ахлах) байцаагчийн үйл ажиллагаа, хяналт шалгалттай хамааруулан гаргасан гомдлыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.6 дахь заалтын дагуу салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах

байцаагч хянан шийдвэрлэх бөгөөд бусад дотоод хяналт шалгалтад хамрагдах асуудлыг энэхүү журмын хүрээнд шалган шийдвэрлэнэ.

3.4 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой иргэн, Аж аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан гомдол мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалтын дагуу байгууллагын "Ёс зүйн дэд хороо" хянан шалгаж, дүгнэлт гаргана.

Дөрөв. Дотоод хяналт шалгалтын нэгжийн удирдлага, зохион байгуулалт

4.1 Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах чиг үүргийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, агентлаг, харьяа байгууллагын Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн (цаашид "дотоод хяналтын нэгж, албан хаагч" гэх) хариуцан гүйцэтгэнэ.

4.2 Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь сайдын эрхлэх асуудлын хүрээний улсын төсвийн, төрийн өмчит байгууллага, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд энэ журмын хүрээнд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж болно.

4.3 Дотоод хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэж ангилах бөгөөд хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийнэ. Дотоод хяналт шалгалтын удирдамжид дараах зүйлсийг тусгана.

4.3.1 удирдамж баталсан он, сар, өдөр;

4.3.2 хяналт шалгалтын зорилго, үндэслэл;

4.3.3 хяналт шалгалтын төрөл, арга, хэлбэр;

4.3.4 шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах байгууллага, бүтцийн нэгж, албан тушаалтан;

4.3.5 шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч;

4.3.6 шалгалт эхлэх болон дуусах хугацаа;

4.3.7 өмнө хийсэн шалгалтын талаарх мэдээлэл.

4.4 Төлөвлөгөөт хяналт шалгалт нь тухайн байгууллагын жилийн гүйцэтгэлийн болон дотоод хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөнд туссан байна.

4.5 Дотоод хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг энэ журмын 7-д тусгагдсан чиглэлийн хүрээнд дотоод хяналтын нэгж, ажилтны ажлын ачаалал, зарцуулах хугацаа зэргийг харгалзан байгууллагын стратегийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, дээд шатны болон бусад төрийн байгууллагуудаас хийсэн хяналт шалгалт, өгсөн зөвлөмж, түүний хэрэгжилт, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа байгууллага, төсөл, хөтөлбөрөөс ирүүлсэн хүсэлт, албан хаагчдын санал зэрэгт үндэслэн боловсруулна.

4.6 Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа байгууллага, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотойгоор удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдолд үндэслэн "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд

гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн 10 дугаар зүйлд тусгагдсан шаардлагыг хангасан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийнэ.

4.7 Шаардлагатай тохиолдолд дотоод хяналт шалгалтын бүрэлдэхүүнд удирдах албан тушаалтны шийдвэрээр тухайн байгууллага, бүтцийн бусад нэгжийн холбогдох албан тушаалтанг татан оролцуулж болно.

Тав. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтны эрх, үүрэг.

5.1 Хяналт шалгалтын нэгж, ажилтан нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7-д тусгагдсанаас гадна дараах эрх эдэлнэ.

5.1.1 байгууллагын нэгжийн үйл ажиллагаатай танилцах, холбогдох албан хаагчтай уулзалт, ярилцлага хийх, тайлбар авах, хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэх, шаардлагатай бол тухайн байгууллагын байр, тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглах;

5.1.2 дотоод хяналт шалгалт явуулахдаа удирдамж, өргөдөл гомдолд туссан асуудалд хамаарах дотоод нэгжийн болон байгууллагын удирдлага, албан хаагчтай шууд харилцаж ажлыг шалгах, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа, тодруулга авах, илэрсэн зөрчил дутагдлын талаар тайлбар, нотлох баримтыг ажлын 1-3 хоногт гаргуулах;

5.1.3 өмнө хийсэн дотоод болон хөндлөнгийн хяналт шалгалтын материалтай танилцаж, хяналт шалгалтын тайланд ашиглах, өмнө өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэх;

5.1.4 шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавих;

5.1.5 хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

5.2 Хяналт шалгалтын нэгж, ажилтан нь “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7-д тусгагдсанаас гадна дараах үүрэгтэй.

5.2.1 дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь зөвхөн батлагдсан удирдамж, төлөвлөгөөний хүрээнд дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах. Дотоод хяналт шалгалтын дүнг санаатайгаар гуйвуулах, үндэслэлгүй, нотлох баримтаар баталгаажаагүй асуудлыг шалгалтын дүн, тайланд тусгахгүй байх;

5.2.2 илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан, зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэх хууль, тогтоомжийг нэг мөр мөрдөж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

5.2.3 хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр өгсөн зөвлөмжийн биелэлтээр мэдээллийн сан бүрдүүлэн дүн шинжилгээ хийж, удирдлагыг холбогдох мэдээллээр хангах.

5.2.4 дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа шалгалтад хамрагдсан байгууллага, хувь хүний мэдээллийн нууцыг хадгалах;

5.2.5 дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, хяналт шалгалтын тайлан, өгсөн зөвлөмж, гарсан шийдвэр болон шийдвэр зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайланг зохих стандартын дагуу архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгөх.

Зургаа. Дотоод хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг.

6.1 Дотоод хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллага, албан тушаалтан дараах эрхтэй

6.1.1 дотоод хяналт шалгалтын дүгнэлт, тайлантай танилцаж, тайлбар өгөх;

6.1.2 дотоод хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо байгууллагын удирдлага болон дээд шатны байгууллагад холбогдох хуульд заасан хугацаанд гаргах эрхтэй.

6.2 Дотоод хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллага, албан тушаалтан дараах үүрэгтэй.

6.2.1 байгууллага, албан тушаалтан нь хяналт шалгалтын ажилд дэмжлэг тусалцаа үзүүлж, хяналт шалгалт хийж буй байгууллага, албан тушаалтанд шаардлагатай нотлох баримт, мэдээ мэдээллийг шуурхай гаргаж өгөх;

6.2.2 холбогдох арга хэмжээ авах талаар тавьсан шаардлага, өгсөн зөвлөмжийг биелүүлэх.

Долоо. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

7.1 Дотоод хяналт шалгалтыг Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1-д зааснаас гадна дараах чиглэлээр зохион байгуулна.

7.1.1 нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд тухайн байгууллагын ил тод, нээлттэй байдалд хяналт шалгалт хийх;

7.1.2 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын мөрөөр хяналт шалгалт хийх;

7.1.3 өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хянах зорилгоор хяналт шалгалт хийх.

7.2 Дотоод хяналт шалгалтыг зохин байгуулах арга, хэлбэр.

7.2.1 хяналт шалгалтад хамаарах чиглэлээр үйл ажиллагааны болон санхүүгийн архивласан, архивлаагүй цаасан болон цахим баримт бичгийн хүрээнд хяналт шалгалтыг хийх;

7.2.2 тухайн байгууллага, нэгжийн хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, захиргааны хэм хэмжээний акт, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, байгууллага, нэгжийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх;

7.2.3 хяналт шалгалтын явцад мэдээлэл цуглуулах, үр дүнг баримтжуулах зорилгоор мэдээллийн системд нэвтрэх, холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

7.2.4 тухайн байгууллагын мөнгөн хөрөнгө, бараа материал, тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгөд тооллого, үзлэг хийх, баталгаажуулах, тооцооллын үндэслэлийг шалгах;

7.2.5 байгууллагын цахим хаяг болон мэдээллийн самбарт байршуулсан мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

7.2.6 тухайн байгууллагад төрийн бусад байгууллагаас хийсэн хяналт шалгалтын тайлан, акт, албан шаардлага, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, хэрэгжилтийг шалгах, зөвлөмж өгөх;

7.2.7 төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг явуулахдаа удирдах албан тушаалтны хуульд нийцсэн үүрэг даалгавар, өргөдөл, гомдолд дурдсан асуудлын хүрээнд хийх.

Найм. Дотоод хяналт шалгалтын үр дүнг танилцуулж, шийдвэрлүүлэх

8.1 Дотоод хяналт шалгалтын үр дүнгийн талаар танилцуулга бичиж, холбогдох талын санал, нотлох баримтыг хавсарган удирдамжид заасан хугацаанд шалгуулагч этгээдэд танилцуулж баталгаажуулан, байгууллага, нэгжийн удирдлагад танилцуулан шаардлагатай тохиолдолд удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулна.

8.2 Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэрэг, ашиг сонирхлын шинжтэй бол асуудлыг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлнэ.

8.3 Дотоод хяналт шалгалтын үр дүнг үндэслэн гаргасан шийдвэрийг холбогдох байгууллага, нэгж, албан хаагчид хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хяналт шалгалтын үр дүнг удирдлагын шийдвэрээр тухайн байгууллага, нэгжийн хамт олонд нээлттэй танилцуулж болно.

Ес. Бусад

9.1 Дотоод хяналт шалгалтад хамрагдаж буй шалгуулагч дотоод хяналтын нэгж, ажилтанд шаардлагатай мэдээ, судалгаа, нотлох баримт, материал, тайлбарыг шаардсан хугацаанд гарган өгөөгүй, үндэслэлгүйгээр татгалзсан, шалгалт хийхэд саад учруулсан, шалгалтын дүнд нөлөөлөхийг оролдсон, баримт бичгийг гэмтээсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн, дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх саналыг тухайн байгууллагын удирдлагад хүргүүлнэ.

9.2 Дотоод хяналт шалгалтын явц, үр дүн, шалгалттай холбогдох бусад мэдээллийг баталгаажихаас өмнө задруулах, урьдчилан мэдэгдэхийг хориглоно.

9.3 Дотоод хяналтыг хэрэгжүүлж буй албан хаагч шалгалтад хамрагдсан байгууллага, хувь хүний мэдээллийн нууцыг задруулсан, эрх үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан аливаа, дарамт, шахалт үзүүлсэн, хууль тогтоомж, нотлох баримтын хүрээнд буруу дүгнэлт гаргасан тогтоогдвол холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---